



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2023 оны эхний хагас жилийн тайлан

НИРГЭСЭН ХОЙНО НЬ ХАШХИРАВ АА

Ниргэсэн хойно нь хашхирав аа

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй, нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 хувиар нэмэгдлээ. Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү авчээ. Уул уурхай болон худалдааны салбарт олгосон зээлийн хэмжээ буурсан бол үйлчилгээний салбарт зээл олголт нэмэгджээ. Инфляцын өсөлт удааширч, төгрөгийн ханш чангарсны улмаас төгрөгийн хадгаламжийн өгөөж, валютын хадгаламжийн өгөөжийг гүйцэж ирлээ.

Банкны салбарын тогтвортой хөгжилд банк, харилцагч хоёр талын итгэлцэл чухал бөгөөд харилцагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлд Монголын банкны холбооноос “Харилцагчийн эрхийг хамгаалах банкны үйлчилгээний кодекс”-ийг батлан, салбарын хэмжээнд дагаж, мөрдөж эхлээд байна.

Эхний хагас жилд эдийн засгийн өсөлт 6.4 хувьтай гарсан. Оны эхнээс уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөлжээ. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай, бусад салбаруудын өсөлт сул байлаа. Манай улсын валютын нөөц өнгөрсөн онтой харьцуулахад 23 хувиар өссөн ч, 4.5 сарын импортын хэмжээтэй тэнцэж байгаа нь хангалттай биш юм. Ийм түвшинд төгрөгийн бодит ханш чангарч байгаа нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг бууруулж байна.

Хэдий эдийн засаг сэргэлттэй байгаа ч уул уурхайгаас бусад салбаруудын өсөлтийг хангах орчин нөхцлийг бүрдүүлэхгүй бол тогтвортой өсөлтийг хадгалж чадалгүй “Ниргэсэн хойно нь хашхирав” гэгчийн үлгэр болох вий.



2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв. Бизнесийн зээл олголт сэргэж байна.



Банкуудын чанаргүй зээл аажмаар буурч байна.



Банкны салбарын хэмжээнд харилцагчийн эрхийг хамгаалах нэгдсэн стандарттай болж байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Системийн нөлөө бүхий банкууд IPO амжилттай хийж 447 тэрбум орчим төгрөгийг татан төвлөрүүлэв.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж, валютын хадгаламжийн өгөөжийг давлаа.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү авчээ.


Банкууд иргэдэд хэрэглээний зээлийг түлхүү олгожээ.

Уул уурхай болон худалдааны салбарт олгосон зээлийн хэмжээ буурсан бол үйлчилгээний салбарт зээл олголт нэмэгджээ.

Онцлох өөрчлөлт, энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн II улирал

Тэрбум ₮



Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Онолын тодорхойлолт

Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

2023 оны II улирлын гүйцэтгэл

27%

Банкны зээлийн өсөлт хэвийн үргэлжилж байна.

Засгийн газрын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд банк өөрийн эх үүсвэрээр зээл олгож буй нь зээлийн өсөлтийг дэмжлээ.

Иргэдийн зээл түлхүү байгаа нь зээлийн өсөлтийг үргэлжлэхэд голчлон нөлөөллөө.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.


+9%

Зээлийн үлдэгдэл өсөв.

Эдийн засгийг дэмжих
10 их наяд төгрөгийн
хөтөлбөр

Эдийн засгийг сэргээх ЗГ-ын тусгай
сангуудын хөнгөлөлттэй хөтөлбөр

Хүнсний хувьсгал
болон бусад хөтөлбөрүүд



Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд 9 зээл тутмын нэг нь чанаргүй байна.


9%

Эх сурвалж:
Монголбанк
Үндэсний


Зээлийн багцын чанар аажмаар сайжирч байна.

Өрхийн худалдан авах чадвар нэмэгдэж буй нь иргэдийн зээлийн чанарт эергээр нөлөөлж байна. Барилга болон худалдааны салбарын зээлийн чанарт анхаарал хандуулах шаардлагатай байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал




Хугацаагүй хадгаламжид хүү тооцож эхэлсэн нь төгрөгийн харилцах нэмэгдэх шалтгаан боллоо.

Гадаад орчны тодорхой бус байдлаас үүдэлтэй валют хадгалах, нөөцлөх сонирхол иргэдэд байна. Өнгөрсөн жилийн ханшийн эрсдэл дахин учирч болзошгүй гэсэн болгоомжлол иргэдийн дунд байгаа тул валют хадгалгаж байна.

Банкны эх үүсвэр, жил бүрийн II улирал

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн харилцах

40%

НЭМЭГДЖЭЭ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Зээлийн хүү

16.9%

Эх сурвалж: Монголбанк

Хүү тогтвортой байна.

Оны эхний хагаст хүүгийн түвшин тогтвортой буй хэдий ч сүүлийн хагаст буурах хүлээлттэй байна.. Бодлогын хүү өндөр байгаа нь зээлийн хүү аажмаар нэмэгдэх шалтгаан болж байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


11%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 4.3 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны актив 18 хувиар, Хасбанкны актив 22 хувиар тус тус өсжээ.


Банкуудын актив, жил бүрийн II улирлаар харуулав.



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банк болон ХХБ-ны эх үүсвэр 16 хувиар нэмэгджээ..

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн II улирал



2021	2022	2023
Хаан		
ХХБ		
Голомт		
Төрийн банк		
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

12%

НЭМЭГДЭВ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж

10%


Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Зарим банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж буурчээ.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 4.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13 хувиар өсжээ.

Өөрийн хөрөнгөөр бий болгосон ашиг нь хадгаламжийн өгөөжөөс бага түвшинд байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн II улирал



Хувьцааны ханш


Жич: Тухайн банкны хувьцааны ханш нь хөрөнгийн зах зээл дээр хэрхэн өөрчлөгдөж буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Богино хугацаанд ашиг олох сонирхолтой хөрөнгө оруулагчид их байгаа нь хувьцааны ханшийг бууруулах гол шалтгаан болж байна.

Урт хугацааны хөрөнгө оруулалт хийх мэргэжлийн хөрөнгө оруулагчид ховор байна.

Гадаадын хөрөнгө оруулагчид нийт хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцогчдын 2-3%-ийг эзэлдэг.


Банкуудын оны төгсгөлд 2.2 их наяд төгрөгийн хөрөнгө шинээр татах шаардлагатай байгаа нь хөрөнгийн биржийн нэг жилийн арилжааны нийт дүнгээс 13 дахин их байна.



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгджээ.

Банкууд хөрөнгийн зах зээл дээр амжилттай хувьцаагаа гаргасан нь өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлжээ. Эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг хурдасгах хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн II улирал



2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

18%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж


38%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт хэт өндөр хэвээр байна.

Иргэдэд олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй хэвээр байна. Банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт нэмэгджээ.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн II улирал



2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2023 оны эхний хагас жил: Эдийн засгийн өсөлт 6.4 хувьтай гарлаа. Оны эхнээс уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Боловсруулах болон эрчим хүчний салбар сэргэж буй хэдий ч уг сэргэлт харьцангуй сул хэвээр байна. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байна. Эрэлтийн талаас нь харвал хэрэглээ болон цэвэр экспортын хэмжээ нэмэгдсэн нь эдийн засгийн сэргэлтийг нэмэгдүүлсэн бол гадаадын хөрөнгө оруулалт буурч буй нь өсөлтөд сөрөг нөлөө үзүүлжээ. Дэлхийн ихэнх улсуудад бараа бүтээгдэхүүний үнэ буурч буй нь инфляцын нийлүүлэлтийн талын нөлөөллийг бууруулж, өсөлтийн хурд нэлээдгүй саарчээ.

Төлөв байдал: Хэрэв цаашид Оюу толгойн гүний уурхайн олборлолт, түүхий эдийн бүтээгдэхүүний экспортын урсгал хэвийн явагдвал эдийн засгийн өсөлт үргэлжлэх хүлээлтийг буй болгож байна. Цаашлаад эдийн засгийн бусад салбаруудын сэргэлтийг хурдасгах, эдийн засгийг төрөлжүүлэхэд анхаарлаа хандуулахгүй бол БНХАУ-ын эдийн засагт гарч буй өөрчлөлт нь манай улсын эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх төлөвтэй. Засгийн газрын зүгээс үр ашиггүй зардлуудыг бууруулсан нь төлбөрийн тэнцэл дээрх дарамтыг бууруулж ханш тогтворжих нөхцлийг бүрдүүлж байна. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын өсөлтийн хурд саарч байна.


2023 оны эхний хагас жилд эдийн засаг 6.4 хувиар өсөв.

Уул уурхайн салбарын сэргэлт нь тээвэр, агуулахын салбарыг хурдацтайгаар дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийн дийлэнхийг буюу 5.8 нэгж хувийг бүрдүүлжээ. Боловсруулах, эрчим хүчний салбарт сэргэлт ажиглагдаж буй хэдий ч өсөлтийн хурд хангалттай түвшинд биш байна. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбарын сэргэлт удаашралтай байгаа бол барилгын салбарт өсөлт ажиглагдсангүй.



Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдүүлэхгүй бол эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах боломжгүй байна..

Импортын хэмжээ буурч экспортын хэмжээ нэмэгдсэн нь цэвэр экспортын хэмжээг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Хэрэглээний өсөлт үргэлжилсээр байна.




Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 42 хувиар өсжээ.

Нүүрс болон нефтийн экспортын хэмжээ нэмэгдсэн бол бусад түүхий эдийн экспорт хэвийн түвшинд байсан нь худалдааны тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүллээ.

Импортын бараа бүтээгдэхүүний бодит хэмжээ буураагүй хэдий ч гадаад зах зээл дээрх үнийн бууралтаас шалтгаалан импортын хэмжээ аажмаар буурч байна.


Уул уурхайн салбарын сэргэлт нь **экспортын өсөлтөд** эерэг нөлөө үзүүлжээ.

Хувиар




Гадаад орчны эдийн засаг харьцангуй тогтворжсон нь **импортын өсөлтийг** буурахад нөлөөлжээ.

Хувиар



Экспортын нөхцөл байдал сайжирч **худалдааны тэнцэл ашигтай** гарлаа.

Тэрбум,доллар




Төгрөгийн бодит ханш огцом чангарч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.


Төлбөрийн тэнцэл 474 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ашигтай гарчээ.

Экспортын үйл ажиллагаа эрчимжсэн нь төлбөрийн тэнцлийн ашигтай гарахад чухал нөлөө үзүүлээ. Нөгөө талдаа импортын барааны үнэ буурч импортын хэмжээ багассан нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөллөө.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл



Хангалттай хэмжээний валютын нөөцтэй байна.

Валютын нөөц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувь өссөн байна.

Бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ аажмаар тогтворжиж байгаа нь нийлүүлэлтийн гаралтай үнийн түвшний өсөлтийн хурдыг саарахад нөлөөлж байна.

Төгрөгийн хадгаламжийн өгөөж эерэг утгатай болжээ.

Импортын 4.5 сарын хэрэглээг хангах валютын нөөцтэй байна

Сая ам.доллар

6,000

5,000

4,000

3,000

2,000

1,000

0

2021

2022

2023

Сар

12

10

8

6


4

2

0

Хувиар

Инфляцын түвшин аажмаар буурч төгрөгийн хадгаламжийн өгөөж эерэг болж эхэллээ.



Төсвийн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна.


Оюу толгойн гүний уурхайн олборлолт болон уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын сэргэлтээс үүдэлтэй татварын орлого нэмэгдсэн нь төсвийн орлогыг нэмэгдүүлжээ.

Урсгал зардлын 8 орчим хувийн өсөлт нь төсвийн зарлагын дийлэнх хувийг эзэлжээ.

Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурах төлөвтэй байна.


Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 38 хувиар өсжээ

ДНБ-д эзлэх хувиар




Нийт төсвийн зарлага 10 орчим хувиар нэмэгджээ.

ДНБ-д эзлэх хувиар



Төсвийн тэнцэл ашигтай байна

ДНБ-д эзлэх хувиар



ХАРИЛЦАГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОДЕКС



Банкны үйлчилгээний кодекс гэж юу вэ?

Банкны үйлчилгээний кодекс нь үйлчлүүлэгч иргэд, жижиг бизнес эрхлэгчид, батлан даагч нартай харилцахдаа банкууд хэрхэн ажиллах тухай амлалтын багц юм.(Австралийн банкны үйлчилгээний кодекс)

Кодексийн зорилго нь:

- Банкны үйлчлүүлэгчтэй харилцах стандартыг тогтоож банкны үйлчилгээний сайн туршлагыг дэмжин дэлгэрүүлэх;
- Банкны санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх харилцагчдын ойлголт, хүлээлтийг илүү зөв, тодорхой болгох;
- Үйлчлүүлэгч, банк хоорондын шударга, нээлттэй харилцааг дэмжих;
- Банкны системд итгэл итгэлийг нэмэгдүүлэх.(Өмнөд Африкийн банкны үйлчилгээний кодекс)

Агуулга

МБХ-ны Удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хурлын 23/003 тоот тогтоолоор батлагдсан, 10 зүйл 93 заалттай.

1. Удиртгал
2. Нэр томьёо
3. Үндсэн зарчмууд
4. Ерөнхий зүйл
5. Дансны үйлчилгээ
6. Зээлийн үйлчилгээ
7. Төлбөр тооцооны үйлчилгээ
8. Харилцагчийн үүрэг хариуцлага
9. Гомдол шийдвэрлэх
10. Бусад

<https://mba.mn/codex/>

3.1. Итгэлтэй найдвартай байх

“Бид харилцагчдынхаа итгэлийг хүлээж, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэх талаар үргэлж дээд зэргээр чармайж, хүчин зүтгэл гаргах болно. Бид хууль журмыг чандлан сахиж, харилцагчийнхаа байгууллагын болон хувийн нууцыг дээдлэн хамгаална”.

3.2. Шударга, ёс зүйтэй байх

“Бид бүх үйл ажиллагаандаа ёс зүйн болон шударга ёсны өндөр хэм хэмжээг баримталж ажиллана. Харилцагчдадаа хүндэтгэлтэй, хариуцлагатай, найрсаг хандлагыг манай байгууллагын суурь соёл болгон хэвшүүлнэ”.

3.3. Үйлчилгээний чанарт анхаарах

“Бид үйлчилгээнийхээ чанарт байнга анхаарч, бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүртээмжтэй, хүрэлцээтэй байдлаар хүргэхийг хичээнэ. Бид харилцагчдад хэрэглэхэд хялбар, хямд төсөр бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгохыг эрмэлзэж, хариуцлагатай зээлийн соёлыг бий болгоно”.

3.4. Ил тод, хариуцлагатай байх

“Бид харилцагчдад шаардлагатай мэдээллийг ойлгомжтой, тодорхой байдлаар цаг тухайд нь хүргэж байх болно. Бид Тантай харилцахдаа ил тод, үнэнч шударга, хариуцлагатай байх зарчмыг баримтална”.

- Банкууд шинэ хуучин, том жижиг гэлтгүй үйлчилгээний нэг стандарттай болох
- Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах орчин үүсэх(Нэг стандарт, гомдол шийдвэрлэх, хяналт шалгалт)
- Иргэд өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ авах, санхүүгийн боловсрол дээшлэх
- Банк, иргэдийн харилцан итгэлцэл бэхжих
- Банкны системийн хөгжил, тогтвортой байдалд эерэг нөлөөтэй.